



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/74

Баян-Адарга сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын мал эмнэлгийн зориулалттай вакцин хадгалах хөргүүр нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Ганбат	Сумын Засаг даргын Орлогч
Гишүүн:	Б.Баярцэцэг	Мал эмнэлгийн тархвар зүйч
	Д.Дуламсүрэн	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

2. Холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.ЛХАГВАДОРЖ